



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2021/03



ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-14
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	15
Нэг. Эрүүл мэнд.....	16-17
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	18-20
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	21-24
Дөрөв. Гэмт хэрэг.....	25-26
Тав. Мөнгө,зээл	27
Зургаа. Төсөв, санхүү	28-29
Долоо. Үнэ.....	30-33
Найм. Хөдөө аж ахуй	34-36
Ес. Аж үйлдвэр.....	37-41
Арав. Тээвэр.....	42
Арван нэг. Байгаль орчин	43

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2021 оны 03 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2021 оны эхний 3 сард 374 эх амаржиж, 379 хүүхэд шинээр мэндэлж, 95 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 15(4.2%)-ээр, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үес 18(5.0%)-аар, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 6(6.7%)-аар тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 284 болж өмнөх оны мөн үеийнхээс 12(4.4%)-оор өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 20.8, нас баралт 1.3 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.9 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2018-2021 оны 03 сард



Он гарсаар нялхсын эндэгдэл 4 байгаа нь өмнөх оны мөн үеэс 42.9 хувиар буурчээ.



1.2 Эрүүл мэнд


2021 оны 03 сарын байдлаар 109.2 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар өсч, 3.9 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 20.4 хувиар буурч, 3.2 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар өссөн байна.

2021 оны 03 сард 464 эх жирэмсний хяналтанд орсны 91.8 хувь буюу 426 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 4.6 мянган удаа гарсны 0.7 мянга буюу 15.2 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 24.6 хувиар буурч, алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 36.4 хувиар буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 570 хүн бэртэж, 15 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 84(12.8%)-аар буурч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2021 оны 03 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 31.6 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 25.3 хувь, бусад төрлийн өвчин 18.9 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант үхэл 15.8 хувь, хоол шингээх эрхтний өвчин 8.4 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 124 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 96-өөр буюу 53.4 хувиар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад цусан суулга 66.7 хувиар, бусад 54.5 хувиар заг хүйтэн 47.7 хувиар, тэмбүү 30.8 хувиар трихоминиаз 28.0 хувиар буурсан тус тус голлон нөлөөлжээ.




1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэд 2021 оны 03 сарын эцэст 314 болсны 248 (79%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 66 (21%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 66 (26.6%) хүнээр, өмнөх сараас 13 (4.3%) хүнээр тус тус өсчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 174(55.4%) нь бүрэн дунд, 69(22.0%) нь дээд, 35(11.1%) нь тусгай дунд, 16(5.1%) нь бүрэн бус дунд, 13(4.1%) нь техник мэргэжлийн, 4(1.3%) боловсролгүй, 2(0.6%) бага, 1(0.3%) магистр, докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2021 оны 03 сард




Хөдөлмөрийн хэлтэст 2021 оны эхний 3 сарын байдлаар 43 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 71 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 133 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.



1.4 Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 3 сард 13246.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2510.1 (23.4%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 3 сард өмнөх оны мөн үеэс 2510.1 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 2487.5(36.7%) сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 452.1(25.6%) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгал 34.3(4.5%) сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2021 оны 03 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 15463.0 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 771.8(5.3%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 11613.6(75.1%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2107.7(13.6%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 835.2(5.4%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 643.8(4.2%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 262.7(1.7%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг





Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2021 оны 03 сард нийгмийн халамжийн сангаас 10000 иргэнд 1559.0 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 7660(43.4%)-аар, олгосон тэтгэвэр тэтгэмж 777.1(33.3%) сая төгрөгөөр тус тус буурчээ. Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт буурсан нь 2020 оны 09-р сараас эхлэн цалинтай ээж хөтөлбөр, жирэмсэн эхийн тэтгэмж, алдарт эхийн одонгийн тусламж, насны хишиг, ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж, өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмжүүд и-халамж цахим системд шилжиж ХХҮЕГ-аас шууд арилжааны банк руу шилжүүлэг хийгддэг болсонтой холбоотой юм.


Халамжийн тэтгэвэрт 2021 оны 03 сард 1302 хүн хамрагдсан нь өмнөх оноос 22(1.7%)-аар, олгосон тэтгэвэрийн хэмжээ 170.9(24.7%) сая төгрөгөөр өсчээ.

Халамжийн тэтгэмжид 1081 хүн хамрагдсан нь өмнөх оноос 71(7.0%)-аар, олгосон тэтгэмжийн хэмжээ 41.7(16.3%) сая төгрөгөөр өсчээ.


Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 748 иргэнд 220.0 сая төгрөг, нийгмийн халамжийн сангаас 7 иргэнд 8.4 сая төгрөг тус тус олгожээ.

Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 6862 иргэн хамрагдаж, 169.8 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/





1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2021 оны эхний 3 сарын байдлаар 113 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 44 хүн гэмтэж, 6 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 8(7.6%)-аар, гэмтсэн хүний тоо 19(76.0%) -өөр, нас барсан хүний тоо 4(3 дахин)-өөр тус тус нэмэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 4(5 дахин)-өөр, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4(5 дахин)-өөр, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4(5 дахин)-өөр, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 20(2 дахин)-оор, нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1(50.0%)-ээр тус тус өсч, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 9(16.6%)-өөр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1(25.0%)-ээр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 12(85.7%)-оор тус тус буурч, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 39.8 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 33.6 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 4.4 хувийг хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 4.4 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 4.4 хувийг олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 13.4 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 25 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13(2дахин)-аар нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Өргөн, Хатанбулаг, Хөвсгөл, Сайшанд, Замын-Үүд сумдад нэмэгдэж, Иххэт, Сайхандулаан, Улаанбадрах, Эрдэнэ сумдад өмнө онтой адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 123.4 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 147.5(54.4%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 62.3(50.5%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 51(45.1%) нь гэр орон сууцандаа, 25(22.1%) нь согтуугаар, 11(9.7%) нь гудамж олон нийтийн газарт, 6(5.3%) бүлэглэн, 8(7.1%) хувийг эмэгтэй хүн оролцон, 25(22.1%) нь шөнийн цагаар /22-06 цагт/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 331 хүн саатуулагдаж, 32 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2021 оны 03 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк

Монгол банкны 3-р сарын мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 37.0 мянга болж өмнөх оноос 2.9(8.5%) мянган хүнээр өсч, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 78.4 мянга болж өмнөх оны мөн үеээс 5.8 хувиар өссөн байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2020-2021 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2020-2021 он, мян.хүн




Нийт хадгаламжийн үлдэгдэл 173.1 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 2208.1 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дунджаар 2431.4 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47.7(38.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 7.4 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 76.6(1.0%) сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 947.4(11.3%) сая төгрөгөөр буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр буурчээ.

Чанаргүй зээл сарын эцэст 12.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 316.0(2.4%)сая төгрөгөөр өсж, өмнөх оны мөн үеэс 4818.6(62.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.9 пунктээр өссөн байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2021.03 сард



Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2021.3 сард






2.2 Төсөв, санхүү

2021 оны 03 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 7140.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 77.9 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 18.6 хувиар буурсан байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 92.7 хувийг татварын, 6.4 хувийг татварын бус орлого, 0.9 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2021 оны 03 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 2404.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 1288.6 (34.9%) сая.төг-өөр бага, төлөвлөгөөнөөс 495.4 (26.0%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 03 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 2.8 хувь, бусад бараа үйлчилгээний бүлэг 2.2 хувь, тээврийн бүлэг 0.8 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 0.6 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 0.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.4 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.


Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 хувиар өсөхөд: эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 6.8 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 5.6 хувь, хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 5.5 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 5.5 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 4.4 хувь, бусад бараа үйлчилгээний бүлэг 1.4 хувь, орон сууц,

ус, цахилгаан, түлшний бүлэг 1.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 0.9 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 0.1 хувь, хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2021 оны 03 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020-2021 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2017 -2021 оны 03 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт




3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2020 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1083.4 мянган хээлтэгч малын 209.7 мянга (19.3%) нь 2021 оны эхний 03 сард төллөсөн байна. Эм хонины 24.5 хувь, эм ямааны 18.0 хувь, үнээний 4.2 хувь, ингэний 8.0 хувь, гүүний 1.6 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.0 хувь буюу 208.0 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 38.0 (84.5%) мянгаар бага байна. Алтанширээ суманд 33.1 мянга, Хатанбулаг суманд 24.8 мянга, Сайхандулаан суманд 20.4 мянга, Эрдэнэ суманд 18.4 мянган, Улаанбадрах суманд 18.3 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 55.4 хувийг эзэлж байна.


Том малын зүй бус хорогдол 2021 оны эхний 03 сарын байдлаар аймгийн хэмжээнд 21620 болж, өмнөх оны мөн үеэс 21449 (126 дахин) толгойгоор илүү байна. Энэ оны 01 сард Өргөн, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдын газар нутгаар нойтон цастай, 03 сард аймгийн нийт нутгаар хүчтэй шороон шуурга шуурч цаг агаарын аюултай үзэгдлийн улмаас том мал олноор хорогджээ. Нийт хорогдсон малын 53.7 хувийг ямаа, 37.7 хувийг хонь эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 03 сард



Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Улаанбадрах суманд хамгийн их буюу 1300.0 мянган төгрөг, Алтанширээ, Мандах, Эрдэнэ суманд хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Улаанбадрах суманд их буюу 1050.0 мянган төгрөг, Сайхандулаан суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, хязаалан гуна Дэлгэрэх суманд хамгийн их буюу 1800.0 мянган төгрөг, Алтанширээ, Хөвсгөл, Эрдэнэ сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Замын-Үүд суманд хамгийн их буюу 240.0 мянган төгрөг, Улаанбадрах суманд хамгийн бага буюу 132.5 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Эрдэнэ сумдад хамгийн их буюу 180.0 мянган төгрөг, Алтанширээ суманд хамгийн бага буюу 80.0 мянган төгрөг байна.

Зураг. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ, 2021 оны 03 сард мянган төгрөгөөр



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 03 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 43666.3 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 89615.1 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 3.1 дахин, борлуулалт 2.5 дахин тус тус нэмэгджээ.

2021 оны 03 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 3.1 дахин нэмэгдэхэд уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 20864.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 8.6 хувийг төрийн, 91.4 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 8.6 хувь, компани 90.8 хувь, өрхийн аж ахуй 0.6 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ус түгээлт 6.1 мян.м3-ээр, сувагжуулалт 15.1 мян.м3-ээр, савласан ус 212.9 мян.литрээр, нарийн боов 3.6 тн-оор, бялуу 0.9 тонноор, хиам 4.3 тн-оор, сүү, сүүн бүтээгдэхүүн 2.2 мян.литрээр, нүүрс 312.4 мян.тн-оор тус тус илүү үйлдвэрлэгджээ.



3.3 Тээвэр

2021 оны 3-р сарын байдлаар 167.3 мянган тонн ачаа тээвэрлэж, 16392.8 мянган тонн км-ын ажил, 0.5 мянган зорчигч тээвэрлэж, 237.5 мянган хүн,км-ын ажил гүйцэтгэсэн байна. Тээвэрлэлтийн нийт орлого 4861.7 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 86.2 хувиар өссөн байна.



Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

Температур: 3 дугаар сарын дундаж агаарын температур Дэлгэрэх суманд -0.2 градус хүйтэн, бусад сумдын нутгаар 0.2...4.0 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт нутгаар 15-22 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД /-тай харьцуулахад: Нийт нутгаар ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө -15.0...-20.0 градус хүйтэн, өдөртөө нийт нутгаар 29...38 градус дулаан байв.

Хур тунадас: 3 дугаар сард нийт нутгаар хур тунадас, нойтон цас орж 1...3 өдөр хур тунадастай байж, 0.0...2.4 мм хур тунадас, нойтон цас орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: **1.** Аланширээ, Иххэт сумдад ОЖД-аас ахиу, **2.** Сайншанд, Замын-Үүд, Мандах, Хөвсгөл, Эрдэнэ, Айраг, Өргөн, Сайхандулаан, Хатанбулаг сумдад ОЖД-аас бага, **3.** Дэлгэрэх, Улаанбадрах сумдад ОЖДундаж орчим хур тунадас, нойтон цас орсон байна.

Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд 3-р сарын 13-аас 14-ний, 27-аас 28-ны өдрүүдэд **нийт нутгаар хүчтэй шороон шуурга шуурч цаг агаарын аюултай үзэгдэл ажиглагдлаа.** Сайншанд суманд 31 м/с, Мандах суманд 27 м/с, Айраг суманд 24 м/с, Алтанширээ суманд 22 м/с, Дэлгэрэх, Улаан-Уул сумдад 23 м/с, Замын-Үүд, Хөвсгөл, Өргөн, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг сумдад 20 м/с, Иххэт суманд 16 м/с хүрсэн. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Айраг, Алтанширээ, Иххэт, Өргөн, Хатанбулаг сумдад 1...7, бусад сумдад 11-18 өдөр байлаа.

Цасан бүрхүүлийн байдал: 3 дугаар сард 2 дугаар 10 хоногт Замын-Үүд сумын нутгаас бусад сумдын нутгаар 0.0...2.0 см зузаан, Замын-Үүд сумаас бусад сумдын нумдын нутгаар тарлантсан 5-10 баллын цасан бүрхэцтэй байна. Бусад 1, 3-р 10хоногт цасны зузаан 5 см хүрэхгүй, цасгүй байна.

МАА-н үйлдвэрлэлд: Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй. Нийт нутгаар малын усан хангамж дунд зэрэг, худагт усалж байна.

_____ о О о _____

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**
(2021 ОНЫ 03 ДУГААР САРЫН БАЙДЛААР)**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2021 2020
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хүн	69.6	69.8	71.2	71.5	100.4
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	352	314	361	379	105.0
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	90	103	89	95	106.7
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	262	211	272	284	104.4
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	1	2	7	4	57.1
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	2.8	6.4	19.4	10.6	54.4
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	696	657	248	314	126.6
- Үүнээс эмэгтэй	тоо	353	356	123	134	108.9
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	237	203	53	73	137.3
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	3	3	32	43	134.4
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	3	2	32	35	109.4
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	1	0	0	
Түр	тоо				8	
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	147	196	220	124	56.4
- 10000 хүнд ногдох	тоо	21	28	31	18	56.9
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	144	108	107	113	105.6
- 10000 хүнд ногдох ***	тоо	33	24	24	26	109.3
6.Бойжиж буй төл	толгой	180562	208269	246091	208043	84.5
- Унага	толгой	2073	692	1308	1070	81.8
- Тугал	толгой	1000	1497	2408	1710	71.0
- Ботго	толгой	1583	1564	2313	1451	62.7
- Хурга	толгой	100368	117528	140105	116591	83.2
- Ишиг	толгой	75538	86988	99957	87221	87.3
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	29051.7	39920.0	13825.1	43666.3	3.1 ²
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	37642.7	66463.2	35256.0	89615.1	2.5 ²

* - 2018,2019,2020 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2020 I-III	2021 I-III	Өсөлт	
		Тоо		Хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	104.4	109.2	4.8	104.6
2. Ор хоног	мян.хүн	33.3	27.7	-5.6	83.2
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	2.9	3.2	0.3	110.3
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	4.9	3.9	-1.0	79.6
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	6.1	4.6	-1.5	75.4
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.1	0.7	-0.4	63.6
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	654	570	-84	87.2
Үүнээс: нас баралт	хүн	15	15	0	100.0
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	474	464	-10	97.9
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	434	426	-8	98.2
8. Амаржсан эх	хүн	359	374	15	104.2
Үүнээс: нас баралт	хүн	1	0	-1	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	0	1	1	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	7	4	-3	57.1

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 03 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Дүн	374	0	379	4	1
Айраг	1		1		
Алтанширээ					
Даланжаргалан					
Дэлгэрэх	1		1		
Иххэт	1		1		
Мандах					
Өргөн					
Сайхандулаан	1		1		
Улаанбадрах					
Хатанбулаг	2		2		
Хөвсгөл					
Эрдэнэ					
Сайншанд	267		270	3	1
Замын - Үүд	101		103	1	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 03 сард

Үзүүлэлт	2020 I-III	2021 I-III	Өсөлт	
	Тоо	Тоо	Тоо	Хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	220	124	-96	56.4
Вируст гепатит	1		-1	0.0
Сүрьеэ	17	16	-1	94.1
Тэмбүү	26	18	-8	69.2
Заг хүйтэн	65	34	-31	52.3
Трихоминиаз	25	18	-7	72.0
Цусан суулга	9	3	-6	33.3
Бусад	77	35	-42	45.5

Тайлбар -²-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 03 сард

Боловсролын түвшингээр	2018 III	2019 III	2020 III	2021 III	2021 III 2018 III	2021 III 2020 III
	хүний тоо				хувь	
ДҮН	696	657	248	314	45.1	126.6
Үүнээс: Эмэгтэй	353	356	123	134	38.0	108.9
Магистр, доктор	1	1	1	1	100.0	100.0
Дээд боловсролтой	166	124	77	69	41.6	89.6
Тусгай дунд	34	40	22	35	102.9	159.1
Техник мэргэжлийн	49	44	16	13	26.5	81.3
Бүрэн дунд	392	349	113	174	44.4	154.0
Бүрэн бус дунд	35	63	16	16	45.7	100.0
Бага	6	21	0	2	33.3	
Боловсролгүй	13	15	3	4	30.8	133.3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.2 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 03 сард

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2020 III	2021 III	2020 I-III	2021 I-III	2020 I-III	2021 I-III
ДҮН	248	314	20	71	253	289
Айраг	9	3	0	0	13	1
Алтанширээ	5	7	0	1	6	6
Даланжаргалан	4	7	0	0	4	1
Дэлгэрэх	2	0	0	0	5	1
Иххэт	7	0	1	0	7	0
Мандах	2	6	0	0	2	1
Өргөн	2	2	0	0	4	0
Сайхандулаан	4	1	0	0	4	1
Улаанбадрах	5	3	0	0	10	0
Хатанбулаг	3	7	15	24	16	29
Хөвсгөл	1	0	0	0	2	0
Эрдэнэ	10	14	1	1	10	13
Сайншанд	137	186	3	23	144	152
Замын - Үүд	57	78	0	22	26	84

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 2021 оны 03 сарын эцэст

Салбарын ангилал	2020 I-III	2021 I-III
	Тоо	
Бүгд	99	89
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт		
Уул уурхай олборлох аж үйлдвэр		1
Боловсруулах үйлдвэрлэл		3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1	2
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын Барилга	32	20
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар		4
Тээвэр агуулахын үйл ажиллагаа		5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		
Мэдээлэл, холбоо		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа		2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1	
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7	13
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан Боловсрол	17	1
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	16	1
Урлаг, үзвэр,тоглоом наадам	7	4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5	
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	13	32

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 2021 оны 03 сарын эцэст

Үзүүлэлт	2020 I-III	2021 I-III
	Тоо	
Бүгд	99	89
Менежер	2	3
Мэргэжилтэн	44	27
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	3	4
Контор, үйлчилгээний ажилтан	3	5
Худалдаа, үйлчилгээний ажилтан	11	8
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	0
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан	3	27
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	6	6
Энгийн ажил мэргэжил	1	9
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	26	0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 03 сард

Үзүүлэлт	2020 I-III		2021 I-III	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	хүний тоо			
Бүгд	20	11	71	27
Менежер	0	0	3	2
Мэргэжилтэн	5	5	24	15
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	1	1	4	3
Контор, үйлчилгээний ажилтан	0	0	5	4
Худалдаа, үйлчилгээний ажилтан	8	4	3	3
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	0	0	0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	0	0	18	0
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	4	0	6	0
Энгийн ажил мэргэжил	1	1	8	0
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	1	0	0	0

3.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2021 оны 03 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар		
			Байнга	Улирал	Түр
	хүний тоо				
Бүгд	43	16	35	0	8
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0	0	0		
Уул уурхай олборлолт	0	0	0		
Боловсруулах үйлдвэрлэл	3		3		
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж	0		0		
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	0		0		
Барилга	3	1	3		
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	0		0		
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	10	1	10		
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2	2	2		
Мэдээлэл холбоо	0		0		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2	1	2		
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0	0		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	13	4	5		8
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7	4	7		
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	1	1	1		
Боловсрол	2	2	2		
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0		0		
Урлаг үзвэр тоглоом наадам	0		0		
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0		0		
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	0		0		
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	0		0		

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 03 сард

Үзүүлэлт	2020 I-III	2021 I-III	2021 I-III 2020 I-III
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	10 735.9	13 246.0	123.4
Тэтгэврийн даатгалын сан	6 772.8	9 260.3	136.7
Тэтгэмжийн даатгалын сан	766.6	800.9	104.5
Эрүүл мэндийн даатгалын сан	1 765.7	2 217.8	125.6
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1 120.4	808.0	72.1
Ажилгүйдлийн даатгалын сан	310.4	159.0	51.2
Нийгмийн даатгалын сангийн зарлага	14 691.2	15 463.0	105.3
Тэтгэврийн даатгалын сан	10 609.0	11 613.6	109.5
Тэтгэмжийн даатгалын сан	1 020.2	835.2	81.9
Эрүүл мэндийн даатгалын сан	1 730.6	2 107.7	121.8
ҮОМШӨ*-ний даатгалын сан	640.8	643.8	100.5
Ажилгүйдлийн даатгалын сан	690.6	262.7	38.0

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 03 сард

Үзүүлэлт	2020 I-III	2021 I-III	2021 I-III 2020 I-III
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	17863	18163	101.7
Албан журмаар даатгуулагчид	15817	15735	99.5
Аж ахуй нэгж, байгууллага	8121	8019	98.7
Төсөвт байгууллага	7696	7716	100.3
Сайн дураар даатгуулагчид	2046	2428	118.7
2. Тэтгэвэр авагчдын тоо	8970	9428	105.1
Өндөр насны тэтгэвэр	6526	6908	105.9
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1312	1396	106.4
Тэжээгчээ алдсаны	501	487	97.2
Цэргийн тэтгэвэр	471	491	104.2
ҮОМШӨ*-ний	160	146	91.3
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	11 147.3	11 829.0	106.1
Өндөр насны тэтгэвэр	7 828.3	8 697.3	111.1
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1 231.0	1 343.0	109.1
Тэжээгчээ алдсаны	496.7	502.6	101.2
Цэргийн тэтгэвэр	950.5	1 062.9	111.8
ҮОМШӨ*-ний	640.8	223.2	34.8

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2020 I-III	2021 I-III	2021 I-III 2020 I-III
	сая төгрөг		хувь
ДҮН	10735.9	13246.0	123.4
Айраг	190.0	178.4	93.9
Алтанширээ	76.1	81.9	107.6
Даланжаргалан	440.0	431.4	98.0
Дэлгэрэх	83.1	76.1	91.6
Иххэт	166.7	178.3	107.0
Мандах	91.6	89.2	97.4
Өргөн	257.9	290.6	112.7
Сайхандулаан	94.4	84.5	89.5
Улаанбадрах	92.6	100.4	108.4
Хатанбулаг	196.0	206.6	105.4
Хөвсгөл	85.5	96.0	112.3
Эрдэнэ	160.8	175.6	109.2
Сайншанд	5839.9	7940.6	136.0
Зүүнбаян баг	381.3	363.0	95.2
Замын-Үүд	2580.0	2953.4	114.5

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2020 I-III	2021 I-III	2021 I-III 2020 I-III
	сая төгрөг		хувь
ДҮН	14691.2	15463.0	105.3
Айраг	685.0	712.7	104.0
Алтанширээ	262.8	289.3	110.1
Даланжаргалан	656.4	647.3	98.6
Дэлгэрэх	309.2	340.2	110.0
Иххэт	493.9	514.6	104.2
Мандах	312.5	325.0	104.0
Өргөн	464.3	471.4	101.5
Сайхандулаан	219.9	246.4	112.1
Улаанбадрах	308.9	351.3	113.7
Хатанбулаг	529.4	581.0	109.7
Хөвсгөл	261.7	284.2	108.6
Эрдэнэ	490.0	529.1	108.0
Сайншанд	6379.6	6764.1	106.0
Зүүнбаян баг	557.7	521.9	93.6
Замын-Үүд	2759.9	2884.5	104.5



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 03 сард

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2021 I-III	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2021 I-III
	2020 I-III	2021 I-III	2020 I-III	2020 I-III	2021 I-III	2020 I-III
	тоо		хувь	сая төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	17660	10000	56.6	2336.2	1559.0	66.7
1. Халамжийн тэтгэвэр	1280	1302	101.7	691.7	862.6	124.7
Ахмад настны тэтгэвэр	90	102	113.3	46.8	58.8	125.6
Хөдөлмөрийн чадвараа 50-69% алдсан ХБИ	362	357	98.6	190.1	204.4	107.5
Хөдөлмөрийн чадвараа 70%-с дээш алдсан ХБИ	446	467	104.7	239.1	268.9	112.4
16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	1	1	100.0	0.6	0.6	104.7
Өрх толгойлсон эх/эцэг/-ийн халамжийн тэтгэвэр	0	0		0.0	0.0	
Тэжээгч нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр	381	375	98.4	215.1	330.0	153.4
2 Халамжийн тэтгэмж	1010	1081	107.0	256.4	298.1	116.2
Эмнэлгийн хяналтад байдаг асаргааны тэтгэмж	0	0		0	0.0	
Ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	495	512	103.4	112.7	127.1	112.8
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	224	248	110.7	75.7	92.2	121.7
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18-аас дээш насны хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	236	267	113.1	53.5	63.7	119.0
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	47	44	93.6	12.6	12.5	99.0
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	5	4	80.0	1.1	1.0	88.9



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2021 I-III 2020 I-III	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2021 I-III 2020 I-III
	2020 I-III	2021 I-III		2020 I-III	2021 I-III	
	тоо		хувь	сая төгрөг		хувь
Тэжээн тэтгэх хүүхэдгүй, төрөл садангийн хүнгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	3	6	200.0	0.7	1.5	206.9
3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0	0.0	0	0	0.0
4. Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	578	748	129.4	121.1	220.0	181.6
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	223	251	112.6	99.4	188.5	189.6
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	355	497	140.0	21.7	31.5	145.0
5. Нийгмийн халамжийн сан	17	7	41.2	20.4	8.4	41.2
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	1	1	0.0	1.2	1.2	0.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	15	5	33.3	18.0	6.0	33.3
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	0	1		0.0	1.2	
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн	1	0	0.0	1.2	0.0	0.0
6. Бусад халамжийн дүн	14775	6862	46.4	1245.6	169.8	13.6
Жирэмсэн эхийн тэтгэмж	679		0.0	23.3		0.0
